



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 1/288

Булган

**Гэрээгээр гүйцэтгэх нэмэлт ажлын  
жагсаалт батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 80 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд гэрээгээр хийгдэх тохижилт, бүтээн байгуулалтын нэмэлт ажлын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.
2. Гэрээгээр гүйцэтгэх нэмэлт ажлын жагсаалтын дагуу гүйцэтгэгч компаниудтай хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/ нарт даалгасугай.
3. Нэмэлт ажлыг гэрээний дагуу хугацаанд нь, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг нэр бүхий гүйцэтгэгч компаниудын захирлуудад үүрэг болгосугай.
4. Нэмэлт ажлыг батлагдсан эх үүсвэрээс нь хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын  
10-ны өдрийн 108 дугаар захирамжийн хавсралт

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ НЭМЭЛТ АЖЛЫН ЖАГСААЛТ

Д/Д	Хийгдэж буй ажил	Нэмэлтээр хийх ажил	Нэмэлт гэрээний дүн /төгрөг/	Гүйцэтгэгч
1	Спортын хорооны зүүн урд талын уулзвараас нэгдсэн эмнэлгийн баруун хойд талын уулзвар 0.453 км хатуу хучилттай авто зам барих	Зүүн түрүүний 1.2 км авто замыг засах	40,000,000	"Булган АЗЗА" ТӨХК
2	Булган сумын 3 дугаар багийн А-Б хэсгийн хооронд 0.550 км хатуу хучилттай авто зам барих	Нарны эрчим хүчний гэрэлтүүлэг тавих	8,000,000	"Модерн хас" ХХК
3	Аялал жуулчлалын цогцолбор барих	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хийж гүйцэтгэх	5,600,000	"Ай И Би" ХХК", Баян-Өндөр булаг" ХХК
4	Булган сумын 22 дугаар байрны орчин, нөхцөл, өнгө үзэмжийг сайжруулах	22 дугаар байрнаас соёлын төв хүртэл явган зам тавих	8,800,000	"Цонхот" ХХК
5	Аймгийн баяр наадмын талбайг шинэчлэн засварлах	Сур, шагайн талбай байгуулах, орчныг тохижуулах	30,500,000	"Мөнх Аригу трейд" ХХК
6	Булган сумын гэрэлтүүлгийн өргөтгөл шинэчлэлийн ажил	4 замын уулзвараас Онцгой байдлын газар хүртэл гэрэлт гудамж байгуулах	33,800,000	"Виртуал софт" ХХК
7	Булган сумын гэрэлтүүлгийн өргөтгөл шинэчлэлийн ажил /3 дугаар багц/	Нэгдсэн эмнэлгээс" НИК-Петровис" ШТС хүртэл авто зам дагуу гэрэлтүүлэг	19,400,000	"Оркон тех" ХХК
8	9 дүгээр байр, хуучин халуун ус, Хүний хөгжлийн төв, МСҮТ-ийн зогсоол	АЗДТГ-ын баруун талын авто зогсоолыг өргөтгөх	8,600,000	"Цонхот" ХХК
9	Музейн барилгын засвар	Дотор цахилгааны монтаж шинэчлэх	525,000	"Хурмастын хүлэг" ХХК
	Нийт дүн		155,225,000	